

БАЙГАЛЬ ЦАГ УУРЫН НӨХЦӨЛ

Уул зүй

Физик газарзүйн мужлалаар Говь-Алтайн нурууны зүүн хойд үргэлжлэл болох Их шанхын нурууны уулархаг хэсгийн төв хэсэгт уулс хоорондын хотгор болох Улаан нуурын хөндийд оршдог. Орд нь намхан толгодоор хүрээлэгдэн хагас цөлийн бүсэд, далайн түвшнээс дээш 1490-1590 метрийн өндөрт байрладаг. Улаан нуурын хөндий нь бага зэргийн доворхог гадаргуутай, харьцангуй өндөржилт нь 5-20 метр байна.

Тус бүс нутаг нь төв Азийн гадагшаа урсгалгүй ай савд хамаарах бөгөөд Монгол орны хамгийн гантай бүс нутгийн нэг юм. Гол мөрний сүлжээний нягтшил 0.0-0.05 км² дотор хэлбэлздэг. Хүн малын үндэнд голлон худгийн үс хэрэглэх бөгөөд залуу хагарлууд дагасан дөрөвдөгчийн хурдсанд гар болон өрөмдмөл худгууд гаргасан байдаг. Ус нь эрдэсжилт ихтэй. Харин гүний худгийн үс нь харьцангуй сайн чанартай. ТТ-н орд газар байрлах талбайн хэмжээнд байнгын урсгал үс байхгүй ба хүр бороо элбэг үед хуурай сайр жалга нь түр зуурын урсгал үстэй болох ба уулс хоорондын хөндий, хотгоруудад түр зуурын давсархаг нуурууд үүсдэг. Орд орчимд орших байнгын урсгалтай гол нь ордын талбайгаас 220 км зайд 2960 метр өндөрт орших Онги гол бөгөөд хөрсний үс нь 6 метр гүнд байдаг. Тухайн аймгийн газар нутгийн ихэнх хэсэгт (71.2%) урсацын модуль нь 0.02-0.1 л/с.км², усны нөөцийн потенциалын хэмжээ 397.1 сая.м³/жил. Үүнээс усны нөөцийн потенциал ашиглалт 99.1 сая.м³/жил буюу 25% ба Монгол улсын усны нөөцийг нэгдмэлээр ашиглах, хамгаалах ерөнхий төсөлд тусгагдсанаар нийт урсацын 75% нь түр зуурын урсацын сүлжээ байдаг. Тиймээс урсацын тохируулга хийх, төвийн дүүргийн томоохон голуудаас үс татан усан сан байгуулах замаар томоохон хэрэглэгчийг хангаж болох юм гэж Монгол улсын усны нөөцийг нэгдмэлээр ашиглах, хамгаалах ерөнхий схемд тусгагдсан байдаг.

Цаг уур

Ордын талбай нь цаг агаарын мужлалын хувьд халуун зунтай, хуурайвтар үүр амьсгалын мужид, цасгүй жиндүү хүйтэн өвөлтэй дэд мужид хамаарна. Харин хавар, намрын улиралд цаг агаар ихээхэн тогтворгүй байнга өөрчлөгдөж байдаг. Олон жилийн судалгаанаас харахад дулаан өдрийн дундаж температур 20.2 С°, хүйтэн өдрийн дундаж температур нь -11.5С° байдаг. Жилийн дундаж агаарын температур нь +4-6°С, хамгийн халуун 7-р сард +40°С, хамгийн хүйтэн нь 12-р сард -38°С хүрдэг байна. Агаарын чийг багатай, жилд дунджаар 45-50% байна. Салхины хурд 4-6 м/с, жилд дунджаар 30-35 хоног хүчтэй цасан болон шороон шуургатай өдрүүд тохиолддог. Өвөл цас маш бага унадаг, дунджаар 1-2 см, хамгийн ихдээ 10 см зузаан цасан бүрхүүл тогтоно. ТТ-н районд баруун хойд болон баруун зүгээс ноёлох салхитай. Салхины дундаж хурд 7.5 м/сек, хамгийн их хурд 50.0 м/сек байна. Жилд 154 мм хур тунадас унадгийн 70 хувь нь 6-р сараас 9-р сард унадаг байна.

Ургамлын аймаг

Орд орших бүс нутгийн хэмжээнд ургамлын бүрхэвч багатай ган халуунд тэсвэртэй, шим тэжээл сайтай, жижиг навчит тачир ургамал голлосон 250 гаруй төрлийн ургамалтай бөгөөд түүний дотор хунчир, алтан үндэс, дэгд, сэржмядаг зэрэг олон төрлийн эмийн ургамал элбэг. Хармаг, гоёо, цулхир зэрэг амтлаг ургамал, хайлс, заг, тоорой, жигд гэх мэт мод ургадаг.

Амьтны аймаг

Амьтны аймгаас хар сүүлт, цагаан зээр, хулан зэрэг туурайтан, алаг даага, шар сүүлт, бозлог, хээрийн бор оготоно, туулай зэрэг мэрэгч, үнэг, хярс зэрэг махчин, тагтаа, бор шувуу, хулан жороо, ятуу, ногтруу, хон хэрээ, сар зэрэг байнга нутагладаг жигүүртэн шувуудтай. Мөн ямаан ууц, арваалж зэрэг хортон шавьж тааралдана.